

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/47/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.3 Албан шаардлага.....	Error! Bookmark not defined.
4.4 Зөвлөмж	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/146
танай _____ -ны № _____ -Т

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А.МӨНХ-ОД ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19030/71
D 2022/2021 ON ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,455,218.30	66,826,939.80
35	БАРАА МАТЕРИАЛ	69,455,218.30	66,826,939.80
351	Түүхий эд материал	5,758,961.80	4,293,261.80
35110	Тусгай зориулалттай материал	2,216,461.80	2,051,461.80
35130	Эм боох материал	3,542,500.00	2,241,800.00
354	Хангамжийн материал	55,206,256.50	55,543,678.00
35410	Бичиг хэргийн материал	2,585,340.00	2,228,080.00
35420	Аж ахуйн материал	31,869,366.50	29,307,298.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,606,300.00	1,376,300.00
35460	Хүнсний материал	352,250.00	-
35470	Бусад хангамжийн материал	18,793,000.00	22,632,000.00
35600	Мал амьтад	8,490,000.00	6,990,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,187,878,976.68	2,150,621,732.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,187,878,976.68	2,150,621,732.47
392	Биет хөрөнгө	1,482,854,476.76	1,447,065,732.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,670,283,704.77	2,689,255,204.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,540,513,581.09)	(1,604,127,201.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	230,075,998.00	230,075,998.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(141,276,613.62)	(167,570,556.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	84,108,195.00	86,720,613.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(62,423,923.58)	(64,845,938.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,410,554.50	49,917,086.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,791,656.03)	(39,720,200.06)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,103,850.00	1,103,850.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	418,268,040.33	494,641,388.33
39215	Хуримтлагдсан элэгдэл	(199,807,591.52)	(235,802,010.60)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	7,417,500.00	7,417,500.00
393	Биет бус хөрөнгө	705,024,499.92	703,555,999.92
39301	Програм хангамж	8,007,500.00	8,007,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,441,000.08)	(3,909,500.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	699,458,000.00	699,458,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,257,334,194.98	2,217,448,672.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,257,334,194.98	2,217,448,672.27
51	Засгийн газрын хувь оролцоо	2,257,334,194.98	2,217,448,672.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,262,355,725.35	1,262,355,725.35

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51101	Өмч: - төрийн	1,262,355,725.35	1,262,355,725.35
512	Хуримтлагдсан үр дүн	32,558,946.88	(7,325,566.68)
51210	Өмнөх үеийн үр дүн	32,558,946.88	32,559,956.03
51220	Тайлант үеийн үр дүн	-	(39,885,522.71)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	962,419,522.75	962,418,513.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,257,334,194.98</u>	<u>2,217,448,672.27</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	532,139,921.18	623,503,408.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,580,384.00	113,861,348.00
120	Нийтлэг татварын бус орлого	76,580,384.00	113,861,348.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	76,580,384.00	113,861,348.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	76,580,384.00	113,861,348.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	455,559,537.18	509,642,060.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,118,760.18	70,620,795.19
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,932,393.90	32,935,530.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,186,366.28	37,685,264.29
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	408,440,777.00	439,021,265.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	408,440,777.00	439,021,265.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	539,091,687.13	663,071,743.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	539,091,687.13	663,071,743.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	504,491,270.21	509,931,253.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,882,126.07	204,358,240.76
210101	Үндсэн цалин	153,628,125.01	127,301,636.28
210102	Нэмэгдэл	39,767,458.52	38,183,189.86
210105	Гэрээт ажлын хөлс	40,486,542.54	38,873,414.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,986,378.19	26,574,576.66
210201	Тэтгэврийн даатгал	20,242,059.62	18,745,224.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,381,205.05	2,081,411.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,881,444.05	1,651,688.99
210204	Ажилгүйдлийн даатгал	407,424.47	370,660.46
210205	Эрүүл мэндийн даатгал	4,074,245.00	3,725,590.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,882,347.00	50,187,997.64
210301	Гэрэл, цахилгаан	6,422,667.00	5,728,797.00
210302	Түлш, халаалт	44,459,680.00	44,459,200.64

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	14,381,580.00	21,741,339.63
210401	Бичиг хэрэг	2,505,340.00	2,485,069.63
210402	Тээвэр, шатахуун	10,937,240.00	12,039,940.00
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	606,180.00	680,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	6,010,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	332,820.00	525,880.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	375,020.00	425,500.00
210604	Урсгал засвар	375,020.00	425,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,930,000.00	670,000.00
210702	Дотоод албан томилолт	1,930,000.00	670,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,049,160.00	2,735,912.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,474,205.00	990,304.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	129,208.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	486,800.00	486,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	233,355.00	240,000.00
210807	Газрын төлбөр	-	284,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,004,658.95	203,237,686.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,850,262.00	61,347,881.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	136,154,396.95	141,785,804.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,600,416.92	153,140,490.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	32,591,416.92	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	32,591,416.92	
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,009,000.00	58,038,664.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	56,758,664.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,009,000.00	1,280,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	95,101,826.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	95,101,826.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(6,951,765.95)	(39,568,335.22)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	317,187.49
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	317,187.49
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(317,187.49)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(6,951,765.95)	(39,885,522.71)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	1,262,355,725.35	962,656,165.52	39,274,070.06	2,264,285,960.93
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	236,642.77	236,642.77
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,262,355,725.35	962,656,165.52	39,510,712.83	2,264,522,603.70
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-236,642.77	0	-236,642.77
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-6,951,765.95	-6,951,765.95
10	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	1,262,355,725.35	962,419,522.75	32,558,946.88	2,257,334,194.98
11	2021 оны 1-р сарын 1-нээрс үлдэгдэл	1,262,355,725.35	962,419,522.75	32,558,946.88	2,257,334,194.98
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	1,009.15	1,009.15
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,262,355,725.35	962,419,522.75	32,559,956.03	2,257,335,204.13
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-1,009.15	0	-1,009.15
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-39,885,522.71	-39,885,522.71
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,262,355,725.35	962,418,513.60	-7,325,566.68	2,217,448,672.27

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	457,946,537.18	509,642,060.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	457,946,537.18	509,642,060.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,505,760.18	70,620,795.19
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,932,393.90	32,935,530.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,573,366.28	37,685,264.29
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	408,440,777.00	439,021,265.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	408,440,777.00	439,021,265.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	414,995,660.18	508,142,060.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	414,995,660.18	508,142,060.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,215,243.26	355,001,570.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,882,126.07	204,358,240.76
210101	Үндсэн цалин	153,628,125.01	127,301,636.28
210102	Нэмэгдэл	39,767,458.52	38,183,189.86
210105	Гэрээт ажлын хөлс	40,486,542.54	38,873,414.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,986,378.19	26,574,576.66
210201	Тэтгэврийн даатгал	20,242,059.62	18,745,224.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,381,205.05	2,081,411.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,881,444.05	1,651,688.99
210204	Ажилгүйдлийн даатгал	407,424.47	370,660.46
210205	Эрүүл мэндийн даатгал	4,074,245.00	3,725,590.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,383,059.00	50,187,997.64
210301	Гэрэл, цахилгаан	6,422,667.00	5,728,797.00
210302	Түлш, халаалт	44,960,392.00	44,459,200.64
2104	Хангамж, бараа материалын зардал	15,585,820.00	18,275,149.63
210401	Бичиг хэрэг	3,507,400.00	2,148,409.63
210402	Тээвэр, шатахуун	10,937,240.00	9,196,290.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	541,180.00	680,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	5,650,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,500,000.00

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	1,930,000.00	670,000.00
210702	Дотоод албан томилолт	1,930,000.00	670,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,716,960.00	2,735,912.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,857,205.00	990,304.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	889,600.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	129,208.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	486,800.00	486,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	233,355.00	240,000.00
210807	Газрын төлбөр	00.00	284,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,730,900.00	50,699,693.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,730,900.00	50,595,693.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	104,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,780,416.92	153,140,490.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	32,591,416.92	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	32,591,416.92	
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,189,000.00	58,038,664.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	56,758,664.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,189,000.00	1,280,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	95,101,826.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	95,101,826.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	42,950,877.00	1,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	42,950,877.00	1,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,950,877.00	1,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	42,950,877.00	1,500,000.00
221001	Их засвар	42,950,877.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-42,950,877.00	-1,500,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн н	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	471,122,900.00	367,815,786.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	424,073,800.00	367,815,786.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	366,032,900.00	309,777,122.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,629,800.00	204,358,240.76
210101	Үндсэн цалин	153,201,100.00	127,301,636.28
210102	Нэмэгдэл	47,339,600.00	38,183,189.86
210105	Гэрээт ажлын хөлс	40,089,100.00	38,873,414.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,485,000.00	26,574,576.66
210201	Тэтгэврийн даатгал	22,859,900.00	18,745,224.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,406,300.00	2,081,411.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,925,100.00	1,651,688.99
210204	Ажилгүйдлийн даатгал	481,200.00	370,660.46
210205	Эрүүл мэндийн даатгал	4,812,500.00	3,725,590.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,525,400.00	50,187,997.64
210301	Гэрэл, цахилгаан	7,066,100.00	5,728,797.00
210302	Түлш, халаалт	44,459,300.00	44,459,200.64
2104	Хангамж, бараа материалын зардал	23,624,800.00	18,275,149.63
210401	Бичиг хэрэг	2,100,000.00	2,148,409.63
210402	Тээвэр, шатахуун	9,456,800.00	9,196,290.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	468,000.00	680,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,000,000.00	5,650,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,401,500.00	670,000.00
210702	Дотоод албан томилолт	4,401,500.00	670,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,866,400.00	1,745,608.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	129,208.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	486,800.00	486,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	240,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	284,800.00	284,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	6,465,550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	6,465,550.00

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,040,900.00	58,038,664.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,040,900.00	58,038,664.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,758,700.00	56,758,664.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,282,200.00	1,280,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,049,100.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	47,049,100.00	-
221001	Их засвар	25,000,000.00	-
223001	Бусад хөрөнгө	22,049,100.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	471,122,900.00	367,815,786.69
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	471,122,900.00	367,815,786.69
132001	Орон нутгийн төсвөөс	471,122,900.00	367,815,786.69
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	20.00
620001	Удирдах ажилтан	6.00	5.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
620004	Гэрээт ажилтан	6.00	6.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,724,447.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,724,447.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,724,447.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	990,304.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	990,304.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,734,143.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,630,143.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	46,724,447.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,724,447.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,314,327.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,410,120.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газар нь сумын хэмжээнд төр засгийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт шинжилгээ хийж, үр дүнг тооцох, Засаг даргын Тамгын газрыг мэргэшсэн мэдлэг чадвар бүхий албан хаагчаар бэхжүүлэхэд зохион байгуулалтын болон мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, төрийн захиргааны шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд манлайлан оролцох замаар төрийн захиргааны ажлыг тогтвортой, чанартай шуурхай, стандартын дагуу явуулж, үр дүнд хүргэх зорилго бүхий байгууллага юм.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 7-р сарын 17-ны өдрийн А/10 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийн 2021 оны ажлын төлөвлөгөөнд 6 ажил хийгдэхээр тусгагдаж, хэрэгжүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 623,503.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,352.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,482.0 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 439,021.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 70,620.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого

113,861.3 мянган төгрөг нийт 623,503.4 мянган төгрөг, өмнөх оноос 91,363.4 мянган төгрөгөөр буюу 17 хувиар өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй орлоготой, нэмэлт санхүүжилтийн орлого өссөнтэй холбоотой байна.

Зардал:

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 663,071.7 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 508,142.0 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 367,815.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140355001 тоот дансанд 2021 онд 442,354.5 мянган төгрөгийн орлого, 442,354.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140355408 тоот дансанд 70,770.2 мянган төгрөгийн орлого төвлөрч, 70,770.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна. *Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мян.төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	69,455.2	66,826.9	-2,628.2
Үндсэн хөрөнгө	2,187,878.9	2,150,621.7	-37,257.2
Нийт хөрөнгө	2,257,334.1	2,217,448.6	-39,885.5
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,257,334.1	2,217,448.6	-39,885.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,257,334.1	2,217,448.6	-39,885.5

Бараа материалын дансны үлдэгдэл 66,826.9 мянган төгрөг болж 2,628.2 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,150,621.7 мянган төгрөг болж 37,257.2 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 1,500.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 104,845.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталсан 8,381.9 мянган төгрөг, шилжүүлсэн 1,500.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,217,448.6 мянган төгрөг болж 39,885.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 443,934.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 387,518.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 19,861.0 мянган төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 424,073.8 мянган төгрөг, орон нутгийн давсан орлогоос хөрөнгийн зардалд 47,049.1 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил урсгал засварын зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг бууруулсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 471,122.9 мянган төгрөгийн төсвийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 439,021.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 367,815.8 мянган төгрөгийг зарцуулж, 71,205.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 367,815.8 мянган төгрөг буюу 78.1 хувь байгаа нь орон тоо дутуу ажилласнаас цалингийн зардлын гүйцэтгэл 84.9 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн гүйцэтгэл 81.8 хувь, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч устгах зардлын гүйцэтгэл 51.4 хувь, цар тахалтай холбоотой танхимын сургалт семинар зохион байгуулаагүйн улмаас томилолт, зочны зардлын гүйцэтгэл 15.2 хувь, хөрөнгийн зардлын санхүүжилт дутуу хийгдсэнээс болж 100 хувь зарцуулаагүй зэрэгтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Оны эхний үлдэгдэл 21,412.9 мянган төгрөг байсан ба аймгийн Засаг даргын Тамгын газраас ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 1,500.0 мянган төгрөг, “Төв Чандмань” ДЭХГазраас Засгийн газраас төлсөн усны үнэ 1,616.5 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардалд 532.1 мянган төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газраас малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх зардалд 10,000.0 мянган төгрөг, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хамтарсан багийн санхүүжилтэд 300.0 мянган төгрөг, Дундговь аймгийн Онцгой байдлын газраас сэг зэм устгах зардалд 1,000.0 мянган төгрөг,

Зуунмод сумын Засаг даргын Тамгын газраас сургалтын унааны зардалд 80.0 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс сум, багийн статистик хариуцсан ажилтны сургалтын зардалд 104.0 мянган төгрөг, төрийн албан хаагчдын орон сууцны түрээсийн мөнгө 1,785.2 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 78.9 мянган төгрөг, өвсний мөнгө 17,505.3 мянган төгрөг, ковид 19 цар тахалтай холбоотой иргэн, ААНБ-с өгсөн хандив 14,705.0 мянган төгрөг, нийт 49,207.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 990.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 45,630.1 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 104.0 мянган төгрөг, нийт 46,724.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 23,896.4 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газарт онцолсон асуудал байхгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газарт Шилэн дансны хуулийг хэрэгжилтийг хангуулах зөвлөмж өгсөн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цэсэнд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 136 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл, мэдээлээгүй 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн аудитад шаардлагатай баримт, материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар туслах үйл ажиллагааны төлөвлөлт, худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулахтай холбоотой 2 зөвлөмж өгөгдсөн байна. Хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 24 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт дансан дахь орлогын талаар дараагийн аудитаар авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 97,601.8 мянган төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залруулсан.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авсан 1,500.0 мянган төгрөгийн зардлыг хөрөнгийн зардлаар тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Төсвийн зарцуулаагүй үлдэгдэл болох 95,101.8 мянган төгрөгийг төвлөрүүлснийг буруу кодоор тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Нохой устгалын урьдчилгаа төлбөр болох 1,000.0 мянган төгрөгийг урьдчилгаа дансаар бичилгүй өглөгийн дансанд бичсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын бараа материалын мал амьтад дансан дахь малын тоо нь бодитой оршин байгаа нь эд хөрөнгийн тооллогоор баталгаажгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дэх хэсэг 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

- Байгууллагын дансанд бүртгэлтэй малыг үнэн зөв, бодитоор тоолж зөрүүг шийдвэрлэх.

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цэсэнд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 136 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл, мэдээлээгүй 1 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

- Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд, тухай бүр мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Баян ЗДТГ	5	104,591.8	3	97,601.8	0	0	0	0	2	6,990.0